

# МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 11-р сарын 18-ны өдөр

№ 16/11

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус  
гишүүнийг түр орлох этгээд томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь заалт, 79 дүгээр зүйл, 81 дүгээр зүйлийн 81.5 дахь заалт, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.17.1, 7.17.2 дахь заалт болон 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос гаргасан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 01 тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдээр Очир овогтой Лхагвасүрэнг томилсугай.
2. Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6 дахь заалтын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлохоор томилогдсон О.Лхагвасүрэн нь компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний эрхийг 2021 оны 11 дүгээр сарын 17 өдрөөс эхлэн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд эдлэхийг дурдсугай.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлохоор томилогдсон О.Лхагвасүрэнд Монгол улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн хурлын дэг болон бусад холбогдох компанийн засаглалын эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
4. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээд томилогдсон тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Н.Цагаанхүү/, олон нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ХҮРЭЛБААТАР